



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 23 өдөр

Дугаар A/136

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 10/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэн Баянжаргал овогт Чойдогсүрэнгийн Мөнхбат (ИЭ80010539)-д 3195236 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 1000 м² газрыг орон сууцны зориулалтаар 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газарт эзэмших эрх авсан иргэнтэй гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН